*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАР ТАМХИ, МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ГАНЗОРИГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.4 “Гаалийн байгууллагын дэд бүтэц чадавхийг бэхжүүлэх”** | | | | | | | |
| 1. | Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, бэлэн мөнгө /валют/-ийгулсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдамжаар хангасан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 85% | 100% | - Тайлант хугацаанд хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан 14 удаагийн үйлдлийг таслан зогсоож, таних багажаар шинжилж тогтоох, эзэн холбогдогч болон нотлох баримтын хамт цагдаа, тагнуулын байгууллагад харьяаллын дагуу шилжүүлэн өгөх, хяналтад хүргэхтэй холбоотой зөвлөмж, чиглэлээр харьяа гаалийн газар, хороодын зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан алба, албан хаагчдыг ханган ажилласан.<br>Дээрх гэмт хэргийн шинжтэй зөрчлөөс дурдвал:<br>1. [redacted] – 500 мл (ЧХОУНБГГ) /ЧХОУНБГГ-т ХТМУТХ-ээс ээлжит хяналт шалгалтын ажиллагааг зохион байгуулж ажиллах үед БНТУ-аас ирсэн сэжигтэй зорчигчийн гар тээшийг рентген тоног төхөөрөмжөөр оруулан үзэхэд [redacted] бүхий олон ширхэг зүйл харагдсан. | 2024.01.01-2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тус зорчигчийн гар тээшийг нарийвчлан шалгахад [redacted] тариа 500 мл гарсан бөгөөд харьяалалын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлсэн./<br>2. [redacted] 7.32 грамм (Монгол шуудан дахь гаалийн хяналтын бүс) /УХШИГГ-ын газрын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу очиж [redacted] багажаар шинжилж үзэхэд [redacted] гэх сэтгэцэд нөлөөт бодис болох нь тогтоогдсон тул удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан./<br>3. [redacted] – 7.32 грамм (Ди Эйч Эл дэх гаалийн хяналтын бүс) /УХШИГГ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас [redacted] Улсаас ирүүлсэн илгээмжээс 2 ширхэг [redacted] буюу [redacted] илэрлээ гэх мэдээлэл ирсэн бөгөөд удирдлагаас дээрх илгээмжийг нягтлан шалгах чиглэл өгсөн. УХШИГГ-ын Ди Эйч Эл дэх хяналтын бүсэд очиход тус газрын зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан гаалийн улсын байцаагч нь илгээмжид [redacted] чихэрнээс өөр зүйл байхгүй, та нар хэрэггүй ирлээ гэх зүйлийг ярьсан. Ууттай чихрийг нягтлан шалгахаар уутыг задлахад чихэр дунд нуун далдалсан, зип түгжээтэй уутанд хийсэн [redacted] буюу [redacted] гэх шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодис байсныг илрүүлсэн бөгөөд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу тус хэрэг дээр цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан./<br>4. [redacted] – 94.4 грамм (Монгол шуудан нисэх гаалийн хяналтын бүс) /УХШИГГ-ын газрын Зөрчилтэй тэмцэх албанаас ирүүлсэн сэжиг бүхий | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу нягтлан шалгахаар очиход хуурай маск гэх зүйлийн дотор нуун далдалсан [redacted] гэх мансууруулах бодис байсныг тогтоож тус хэрэг дээр тагнуулын байгууллагатай хамтран ажилласан./<br>5. [redacted] – 5 грамм (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) / УХШИГГ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас [redacted] аас илгээсэн захидал дотроос сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу нягтлан шалгахаар очсон бөгөөд тус зүйлийг [redacted] багажаар шинжлэн үзэхэд [redacted] болох нь тогтоогдсон тул Гаалийн тухай хуулийн 250.1-т Гаалийн байгууллагаас олон улсын гэрээний, эсхүл бусад улсын гаалийн болон эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэхэд тарифын бус хязгаарлалт тогтоосон барааны хууль бус эргэлтийг таслан зогсоох, оролцогч этгээдийг илрүүлэх зорилгоор уг барааг гаалийн хяналт дор хүргэх аргыг хэрэглэж болно гэсэн заалтыг үндэслэн илгээмжийг [redacted] цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан бөгөөд илгээмж хүлээн авагчийг [redacted] нь дайчлан баривчилсан./<br>6. [redacted] - 11 ширхэг (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) /УХШИГГ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас [redacted] Улсаас илгээсэн захидал дотроос сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу нягтлан шалгахаар очсон бөгөөд нарийвчилсан үзлэг шалгалтыг хийхэд [redacted] гэх сэтгэцэд нөлөөт бодис болох | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нь тогтоогдсон тул тус хэрэг дээр цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан./<br>7.[redacted] – 30 мл (Ди Эйч Эл дэх гаалийн хяналтын бүс) /УХШИГГ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас [redacted] Улсаас илгээсэн илгээмж дотроос сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу дүн шинжилгээ хийхэд шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодис болох [redacted] байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар [redacted] байгууллагатай хамтран ажилласан бөгөөд илгээмж хүлээн авагчийг, тус бодисыг захиалсан этгээдийн хамт дайчлан баривчилсан. ШШЕГ-ын дүгнэлтээр тухайн бодис [redacted] болох нь тогтоогдсон./<br>8. [redacted] – 25 грамм (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) /УХШИГГ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас [redacted] Улсаас илгээсэн захидал дотроос сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу дүн шинжилгээ хийхэд [redacted] байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн [redacted] цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж илгээмж хүлээн авагчийг [redacted]<br>9.[redacted] – 50 ширхэг, 152.5 грамм (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) /УХШИГГ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас [redacted] аас илгээсэн илгээмж дотроос сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу дүн шинжилгээ хийхэд [redacted] гэх сэтгэцэд нөлөөт бодис болох нь тодорхой байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | илгээмжийг эзэнд нь олгуулахаар цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж илгээмж хүлээн авагчийг Монгол шуудан ХК-ийн салбараас дайчлан баривчилсан./<br>10. [redacted] – 60 ширхэг (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) /УХШИГГ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас [redacted] илгээсэн илгээмжид лаазалсан [redacted] бэлдэц гэх зүйл байна гэх мэдээллийн дагуу судалгаа, дүн шинжилгээ хийсэн. [redacted] бэлдэц нь лаазалсан хэлбэрээр зарагддаггүй мөн [redacted] бэлдэц нь дамранд ороосон хуванцар утас хэлбэртэй байдаг гэдгийг судалж тогтоосон бөгөөд тухайн илгээмж дотор хар тамхи, мансууруулах бодис байх магадлалтай байсан тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн [redacted] цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг [redacted] Илгээмж хүлээн авагчийг байлцуулан лаазыг задалж үзэхэд 60 ширхэг [redacted] гэх сэтгэцэд нөлөөт бодис байсан./<br>11. [redacted]– 25 дусал (Монгол шуудан-Хөшигийн хөндий гаалийн хяналтын бүс) /УХШИГГ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас Нидерланд Улсаас илгээсэн захидал дотроос сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу дүн шинжилгээ хийхэд "25 drop" гэх шошготой, дусаагуурын савлагаатай шингэн зүйл, "LSZ" гэх шошготой вакум уутгай зүйл байсан. ЛСД гэх сэтгэцэд нөлөөт бодисын шинэ хувилбарыг LSZ гэж нэрлэдэг ба тухайн захидалд хар тамхи, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мансууруулах бодисыг нуун далдалсан болох нь тодорхой байх тул Гаалийн тухай хуулийн 250.1-т заасан заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар тагнуулын байгууллагатай хамтран ажиллаж, илгээмж хүлээн авагчийг Монгол шуудан ХК-ийн салбараас дайчлан баривчилсан. ШШЕГ-ын дүгнэлтээр Монгол Улсад урд өмнө нь бүртгэгдэж байгаагүй шингэн ЛСД болох нь тогтоогдсон./<br>12. [redacted] – 36 грамм (ЧХОУНБГГ) /[redacted] байгууллагаас хамтран ажиллах хүсэлт ирүүлсний дагуу ЧХОУНБГГ-т хамтарсан хяналт, шалгалтын ажиллагаа явуулсан бөгөөд [redacted] ирсэн дайвар ачааг нягтлан шалгахад ягаан өнгийн алчууранд боосон 36 грамм [redacted] буюу Мөс гэх сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлсэн./<br>13. [redacted] 659.1 грамм (Монгол шуудан нисэх гаалийн хяналтын бүс) /УХШИГГ-ын Зөрчилтэй тэмцэх албанаас [redacted] Улсаас илгээсэн илгээмж дотроос сэжиг бүхий зүйл илэрлээ гэх мэдээллийн дагуу дүн шинжилгээ хийхэд [redacted] гэх бичигтэй, дусаагуурын савлагаатай шингэн зүйл байсан. [redacted] гэх сэтгэцэд нөлөөт бодисыг [redacted] хэмээн нэрлэдэг ба тухайн зүйл нь хар тамхи, мансууруулах бодис байх үндэслэлтэй байсан тул илгээмж хүлээн авагчийг саатуулж, цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн. ШШЕГ-ын дүгнэлтээр [redacted] болох нь тогтоогдсон/<br>14. [redacted] – 42.40 грамм (СэГГ) /Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанд ХТМУТХ-ийн удирдлагын зүгээс Улс тунхагласны баярын өдөр тул сонор, сэрэмжтэй ажиллах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чиглэл өгсөн. Тус чиглэлийн хүрээнд ажиллах явцад Алтанбулаг боомтоор улсын хилийн орох чиглэлд хил нэвтэрсэн иргэн Б-гийн өмсөж явсан хувцас дотроос 3 ширхэг уутанд боосон [redacted] 8 ширхэг, нийт 7.2 кг жинтэй засаж, хэлбэр оруулсан чулууг илрүүлсэн/<br>- Монгол Улсын хилээр зорчигчийн гаалийн мэдүүлгээр мэдүүлсэн бэлэн мөнгө (валют)-ний мэдээг 2024.01.01-нээс 2024.11.22-ны өдрийн байдлаар авч үзвэл нийт 12 гаалийн газар, хороодод бүртгэгдсэн нийт [redacted] төрлийн валютаар илэрхийлэгдэх [redacted] тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний) валютыг гаалийн байгууллагад мэдүүлсэн (үүнээс: орох чиглэлд [redacted], гарах чиглэлд [redacted], дамжин өнгөрөх чиглэлд [redacted] мэдээлэл бүртгэгдсэн байна.<br>Гаалийн байгууллагын хэмжээнд 2024 оны байдлаар бэлэн мөнгө /валют/-ийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан [redacted] төгрөгтэй тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий зөрчлийн 1 удаагийн үйлдлийг илрүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан.<br>[redacted] | | |
| 2. | Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажилласанбайдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 86.6% | 100% | **<u>Дэлхийн гаалийн байгууллага</u>**<br>- Дэлхийн гаалийн байгууллагын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 24FL0036E дугаартай албан бичигт "Хуурамч барааны хууль бус эргэлттэй тэмцэх, оюуны өмчийн эрхийг зөрчиж болзошгүй хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй бусад төрлийн хууль бус бараа эргэлтийг таслан зогсоох, тэдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх "Action IPR A/P 3 operation" гэх олон | 2024.01.01-2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | улсын хууль сахиулах ажиллагаар 2024.05.20-ноос 31-ний өдрүүдэд ДГБ-аас зохион байгуулсан ОУ-ын Хууль сахиулах ажиллагаанд оролцож, ажиллагааны явцад харьяа гаалийн газар, хороодыг 2024.05.22-ны өдрийн [redacted] дугаартай албан бичгээр чиглэл мэдээллээр хангаж ажилласан. Ажиллагааны явцад илэрлсэн зөрчил бүртгэгдээгүй.<br>- Дэлхийн гаалийн байгууллагын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн [redacted] дугаартай албан бичигт дурдсан Дэлхийн гаалийн байгууллагын Хууль сахиулах хорооны 2024 оны 3 дугаар сарын 18-ноос 22-ны өдрүүдэд цахим хэлбэрээр явагдах 44 дүгээр хуралд тус хэлтсийн алба хаагч [redacted] зөрчилтэй тэмцэх газрын [redacted] нарын нэрсийг хүргүүлэн хуралд цахим хэлбэрээр оролцсон;<br>- Дэлхийн гаалийн байгууллагын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн [redacted] от албан бичигт дурдсан Дэлхийн гаалийн байгууллага (WCO) болон БНХАУ-ын Гаалийн байгууллага хамтран Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протоколоор олон улсын хяналтад орсон химийн бодис Ozone Depleting Substances (ODS), Гидрофтор нүүрстөрөгч (HFCs) болон Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай базелийн конвенцоор олон улсын хяналтад орсон хуванцар хог хаягдал (plastic waste), цахилгаан, электроник тоног төхөөрөмжийн хог хаягдал (e-waste)-ын хууль бус эргэлттэй тэмцэх Олон улсын хууль сахиулах ажиллагаар Монгол Улсын Гаалийн байгууллага дэмжин оролцсон. Дэлхийн гаалийн байгууллагын Аюултай хог хаягдлын хууль бус эргэлттэй тэмцэх" Олон улсын хууль сахиулах [redacted] ажиллагааны хүрээнд Монгол Улсын Гаалийн байгууллагын 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдөр, Замын-Үүд боомтоор, улсын хилээр гарах чиглэлд илрүүлсэн аюултай | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хог хаягдал байж болзошгүй [redacted] машины батерей буюу цэнэг хураагуур гэх зүйлийг нуусан үйлдлийг илрүүлж, улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан зөрчилд зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасны дагуу арга хэмжээ авч шийдвэрлэсэн.<br>- ДГБ болон Дэлхийн шуудан холбооны хамтарсан Синтетик төрлийн хар тамхины олон улсын шуудан илгээмж дэх хууль бус эргэлтийг илрүүлэх санаачлага (SDDP-MC)-ын төслийн хүрээнд ДГБ болон ДШХ-ны төлөөлөгчид МУ-д 2024 оны 8 дугаар сард ирж ажиллах болсонтой холбоотойгоор Гааль-Шуудангийн байгууллагын хамтын ажиллагааны Ажлын төлөвлөгөөний төслийн боловсруулсан, мөн [redacted] тухай Санамж бичгийн төслийг боловсруулж, ГЕГ-ын ХХ-ээр төслийг хянуулж санамж бичигт 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр гарын үсэг зурах арга хэмжээг ГЕГ-т зохион байгуулсан.<br>- ДГБ-аас ирсэн Судалгааны загварын дагуу 2022 болон 2023 оны сүүлийн хагас жилд илрүүлсэн зөрчлийн мэдээллийг гаргаж 2024.03.20-ны өдрийн Дотоод зурвасаар ГЕГ-ны ГХАХ-т хүргүүлсэн.<br>- НҮБ-ын Мансууруулах эмийн комиссын 2020 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 63, 2021 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 64, 2022 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 65, 2023 оны 7 дугаар сарын 11-ний өдрийн 66 дугаар чуулганаар тус тус баталсан НҮБ-ын Мансууруулах эмийн тухай 1961 оны конвенц, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенц, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны конвенцид тус тус нэмэлт өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг тусгасан олон улсын хяналтад орсон 3[redacted] бодисын жагсаалтыг гаргаж 2024.03.11-ний өдрийн Дотоод зурвасаар | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ГЕГ-ын дэргэдэх ГТЛ-т Барааны ангиллын код тодорхойлуулах хүсэлтийн хамт хүргүүлсэн.<br>- ДГБ-ын Хууль сахиулах хорооноос Стратегийн (хоёрдмол зориулалттай) бараа Худалдааны Хяналтыг Хэрэгжүүлэх чиглэлээр өөрийн гишүүн орнуудад техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор Стратегийн барааны Худалдааны Хяналтыг Хэрэгжүүлэх тухай 2023 онд шинэчлэн гаргасан гарын авлагыг орчуулан гаалийн улсын байцаагч нарын хүртээл болгож өгөх хүсэлтийг ГХАХ-д 2024.03.14-ний өдрийн Дотоод зурвасаар дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>**<u>Хөрш орнууд болон бусад орны гаалийн байгууллагууд</u>**<br>- “Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын ГХЯ хоорондын Консулын XI зөвлөлдөх уулзалттай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай” 1998 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн хэлэлцээрийн 13 дугаар зүйл “Туршлага солилцох”-ийн 2.b-д заасан “гаалийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалт”-ны дагуу тус улсын стратегийн барааны экспортын хяналт, үй олноор хөнөөх зэвсэг бүтээхэд ашиглаж болзошгүй (хоёрдмол зориулалт бүхий) барааны гаалийн хяналт, хууль бус бараа эргэлтийг илрүүлэх талаар туршлага солилцох сургалтад гаалийн ажилтнуудыг хамруулах боломжтой эсэх талаар саналыг 2024.02.20-ны өдрийн Дотоод зурвасаар ГЕГ-ын Гадаад хамтын ажилгааны хэлтэст хүргүүлсэн.<br>- “Хууль сахиулах чиглэлээр хил орчмын бүс нутагт хамтран ажиллах асуудлаар” МУ-ын ГЕГ-ын Зөрчилтэй тэмцэх газар, ОХУ-ын Холбооны гаалийн албаны Контрабандтай тэмцэх ерөнхий газрын харьяа Сибирь болон Алс дорнодын бүсийн гаалийн хууль сахиулах газруудын ажлын долдугаар уулзалттай холбоотой бэлтгэл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлуудыг хангуулж, Чиглэл хүргүүлэх тухай 2024.05.10-ны өдрийн [redacted] тоот албан бичгийг харьяа гаалийн газар, хороодод хүргүүлж, ажлын уулзалтыг зохион байгуулсан.<br>- ОХУ-ны ХГА-ны КТЕГ болон түүний харьяа Сибирь болон Алз дорнодын бүсийн Хууль сахиулах гаалийн газруудтай хийж буй хамтын ажиллагааны хүрээнд ХГА-ны КТЕГ-ын 2 (2024.06.19-ний өдрийн [redacted], 2024.08.16-ны өдрийн [redacted]) албан бичиг, Сибирийн хууль сахиулах газрын 3 (2024.07.10-ны өдрийн [redacted] тоот, 2024.10.14-ний өдрийн 11-22/-06285 тоот, 2024.11.02-ны өдрийн [redacted] тоот) албан хүсэлтийн дагуу холбогдох хариуг хүргүүлсэн.<br>- Бүгд Найрамдах Азербайжан Улсын Гаалийн байгууллагын Мэдээлэл, Дүн шинжилгээ, Мөрдөн шалгах Ерөнхий газрын 2024.02.17-ны өдрийн 3-[redacted] тоот албан хүсэлтийн хариуг Дотоод 2024.03.12-ны өдрийн Дотоод зурвасаар зурвасаар ГХАХ-т хүргүүлсэн.<br>- “[redacted] дамжин [redacted] ХГА-ны 2024 оны [redacted] тоот албан хүсэлтийн хариуг дотоод 2024.05.20-ны өдрийн Дотоод зурвасаар зурвасаар ГХАХ-т хүргүүлсэн.<br>- Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд КОЙКА хамтын ажиллагааны байгууллагын шугамаар 2026 онд хэрэгжүүлэх тусламжийн төсөлд гаалийн байгууллагын Хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм, бусад хориглосон барааг илрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, барааг хууль бусаар хил нэвтрүүлэх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаалийн хяналт шалгалтын сүүлийн үеийн “[redacted] scanner” тоног төхөөрөмжийг [redacted] | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүсэлтийг дотоод зурвасаар 2024.05.22-ны өдрийн Дотоод зурвасаар ГХАХ-т хүргүүлсэн.<br>- АНУ-ын Зэрлэг ан амьтны хууль бус эргэлттэй тэмцэх газраас БНХАУ-ын Бээжин хотноо суух атташе, Жейсон Битти ГЕГ-ын зочлох болсонтой холбоотойгоор АНУ-ын ЭСЯ-ны ирүүлсэн хүсэлтийн дагуу ГЕГ-ын ЗТГ-ын ХТМУТХ-ийн дарга Б.Батгэрэл, ЗТГ-ын ХТМУТХ-ийн ГУАБ Г.Дашням, ГУБ Г.Бат-Эрдэнэ, Хяналт, бүрдүүлэлтийн газрын ГУБ Л.Амартүвшин нар оролцсон.<br>**<u>Дотоодын хууль сахиулах байгууллага</u>**<br>- Тайлант хугацаанд лавлагаа, мэдээлэл хүсэх тухай бусад байгууллага болон хууль хяналтын байгууллагаас ирсэн [redacted] албан бичгийг холбогдох хуулийн хугацаанд хариуг өгч, шийдвэрлэсэн.<br>- Нийслэлийн прокурорын газарт Гаалийн байгууллагын ЗШХА-хийх ЭБАТ-нуудын нэрсийн жагсаалт, холбогдох мэдээлийн судалгааг гаргаж [redacted]ний өдрийн [redacted] тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс хооронд 2024 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх таслах зогсоох чиглэлд хамтран ажиллах төлөвлөгөөг батлуулан 2024 оны 03 дугаар сард батлуулан ажиллаж байна.<br>- Өнгөрсөн онд [redacted] [redacted] Гаалийн байгууллагын дарга нарын хамтран баталсан [redacted] хамтарсан арга хэмжээний үр дүнгийн хэлэлцүүлгийг 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Гаалийн ерөнхий газарт зохион байгуулж "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис", "Түүх соёлын дурсгалт зүйлс", "Алт"-ыг Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх зөрчил, гэмт хэргийн онцлог, гэмт этгээдүүдийн ашиглаж буй арга хэлбэр, хилийн хяналтын байгууллагуудын хэрэгжүүлж буй хяналт, шалгалтад үнэлэлт, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгнэлт хийж цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн хэрэгжүүлэх шаардлагатай ажил, арга хэмжээ, харилцан мэдээлэл солилцох хамтын ажиллагааны талаар хэлэлцэж, улмаар [redacted] байгууллагын төлөөлөл дараах нэгдсэн санал, дүгнэлтийг гаргаж тус тусын байгууллагын удирдлагад танилцуулсан. [redacted] хамтарсан ажиллагааны удирдамжийн төслийг 11-р сард боловсруулж [redacted] байгууллагад [redacted] бичгээр хүргүүлсэн тайлант хугацаанд [redacted] байна.<br>- Хамтын ажиллагааны хүрээнд ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газарт ашиглагдаж байсан “Body scan” буюу зорчигчийн биед биет үзлэг хийх зориулалт бүхий тоног төхөөрөмжийг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр ЧХОУНБ-ын зорчигчийн ирэх талд суурилуулан гаалийн хяналт, шалгалтад ашиглаж байна. Цаашид тус тоног төхөөрөмжийг гаалийн байгууллагын хөрөнгөд бүртгэж шилжүүлэн авсан.<br>- Гаалийн ерөнхий газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс [redacted] хооронд 2024 оны 06 дугаар сард байгуулагдсан Хамтарсан хяналт шалгалт удирдамжийн дагуу Мансуурлах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх таслах зогсоох чиглэлд хамтран ажиллаж байна.<br>- Гаалийн тухай хуулийн 250.1-т Гаалийн байгууллагаас олон улсын гэрээний, эсхүл бусад улсын гаалийн болон эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэхэд тарифын бус хязгаарлалт тогтоосон барааны хууль бус эргэлтийг таслан зогсоох, оролцогч этгээдийг илрүүлэх зорилгоор уг барааг гаалийн хяналт дор хүргэх аргыг хэрэглэж болно гэсэн заалтыг үндэслэн илгээмжийг эзэнд нь олгуулахаар | | |

[redacted], [redacted] хүргэлтийн арга хэмжээг зохион байгуулсан.

- Гаалийн ерөнхий газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс [redacted] хооронд байгуулагдсан Хамтарсан хяналт шалгалт удирдамжийн дагуу ЧХОУНБГГ, ЗҮГГ, УХШИГГ-т нийт [redacted] удаагийн хамтарсан хяналт шалгалтын ажиллагаа явуулсан.
- Орхон, Булган аймаг дахь хууль хяналтын байгууллагуудын хамтран зохион байгуулж буй "Тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын алба хаагчдыг чадавхжуулах хамтарсан сургалт, зөвлөгөөн"-д 2024 оны 09 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд ЗТГ-ын дарга Ж.Эрдэнэболд, Хар тамхи мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн ГУАБ Г.Дашням нар оролцож. "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын алба хаагчдыг чадавхжуулах хамтарсан сургалт, зөвлөгөөн"-д оролцож "Тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтын ажиллагаа", "Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, өнөөгийн байдал" сэдвүүдээр илтгэл тавьсан.
- Хяналт бүрдүүлэлийн газрын хүсэлтийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны удирдлагын хуралд 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр оролцож "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт" сэдвээр илтгэл тавьж улс хоорондын шуудаагийн үйлчилгээ эрхэлдэг ААН-үүдэд хяналт тавих чиглэлээр хэрхэн хамтарч ажиллах талаар санал солилцож 12-р сард багтааж хоёр талт уулзалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

**Гадаад арга хэмжээнд оролцсон байдал**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Дэлхийн гаалийн байгууллагын "Хуурамч барааны хууль бус эргэлттэй тэмцэх, оюуны өмчийн эрхийг зөрчиж болзошгүй хууль бус үйл ажиллагааг илрүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй бусад төрлийн хууль бус бараа эргэлтийг таслан зогсоох, тэдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" ([redacted] гэх хууль сахиулах олон улсын ажиллагааны хүрээнд Япон Улсын Гаалийн байгууллагын санхүүжилтээр ДГБ (WCO) Япон болон Вьетнам Улсын гаалийн байгууллагууд хамтран Ази, номхон далайн бүс нутгийн хэмжээнд дээр дурдсан хууль сахиулах ажиллагааны өмнөх семинарыг Вьетнам Улсын Ханой хотноо 2024.05.14-ноос 17-ны өдрүүдэд оролцсон. Олон улсын энэхүү [redacted] гэх хууль сахиулах ажиллагаанд Монгол Улсын Гаалийн байгууллага 3 дахь удаагаа оролцож байна. Энэхүү ажиллагааны хүрээнд ГЕГ-ын ЭУХ-д 2024.06.18-ны өдрийн Дотоод зурвасаар болон Харьяа Гаалийн газар, хороодод 2024.05.22-ны өдрийн [redacted] дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлэх, мэдээллээр хангах, хэрэг зөрчлийг илрүүлэх чиглэлээр ажиллагсан. Ажиллагааны явцад хэрэг, зөрчил бүртгэгдээгүй.<br>- ДГБ-ын "Синтетик төрлийн хар тамхины ОУ-ын шуудан илгээмж дэх хууль бус эргэлтийг илрүүлэх санаачлага" [redacted] ын төслийн хүрээнд АНУ-ын Төрийн Департаментийн Олон улсын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах товчоо (INL)-ны санхүүжилтээр Дэлхийн гаалийн байгууллага (WCO) болон Дэлхийн шуудан холбоо (UPU) хамтран Ази, номхон далайн бүс нутгийн эхний үе шатны семинарыг бүс нутагт сонгогдсон гишүүн орнууд (Тайланд, Индонез, Монгол, Мальдив, Фижи, Самоа, Саломоны арлууд)-ын хүрээнд Тайланд Улсын Бангкок хотноо 2024.04.22-ноос 26-ны өдрүүдэд, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - ДГБ-ын "Синтетик төрлийн хар тамхины ОУ-ын шуудан илгээмж дэх хууль бус эргэлтийг илрүүлэх санаачлага" ([redacted]-ын төслийн хүрээнд АНУ-ын Төрийн Департаментийн Олон улсын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах товчоо (INL)-ны санхүүжилтээр Дэлхийн гаалийн байгууллага (WCO) болон Дэлхийн шуудан холбоо (UPU) хамтран Ази, номхон далайн бүс нутгийн семинарыг хоёр дахь удаагаа бүс нутагт сонгогдсон гишүүн орнууд (Тайланд, Индонез, Вьетнам, Монгол, Мальдив, Фижи, Самоа, Саломоны арлууд)-ын хүрээнд Бүгд Найрамдах Индонез Улсын Денпасар (Бали) хотноо 2024.09.02-ноос 06-ны өдрүүдэд МУ-ын ГЕГ-ын ХТМУТХ-ийн ГУБ [redacted], Монголшуудан ХК-ийн ОУ-ын шуудангийн газрын дарга [redacted] нар тус тус оролцсон.<br>- Дэлхийн гаалийн байгууллага, БНХАУ-ын Гаалийн байгууллага хамтран Аюултай хог хаягдлын хил дамнасан хууль бус эргэлттэй тэмцэх Олон улсын [redacted] Хууль сахиулах ажиллагааны өмнөх хурлыг БНХАУ-ын Шанхай хотноо 2024.07.02-ноос 04-ний өдрүүдэд.<br>- НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP) болон Дэлхийн гаалийн байгууллага (WCO) хамтран Байгаль орчны асуудал хариуцсан албан хаагч нар болон Аюултай хог хаягдлын хууль бус эргэлттэй тэмцэх" Олон улсын хууль сахиулах [redacted]" ажиллагааны холбоо баригч албан хаагч нарт Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай базелийн конвенцын Цахилгаан, электроник тоног төхөөрөмжийн (Цахим) хог хаягдал (e-waste)-тай холбоотой нэмэлт өөрчлөлтийн талаар сургалтыг Тайланд Улсын Бангкок хотноо 2024.09.09-нөөс 11-ний өдрүүдэд тус тус МУ-ын ГЕГ-ын ХТМУТХ-ийн ГУБ [redacted], БОАЖЯ-ны мэргэжилтэн [redacted] нар тус тус оролцсон. Ажиллагааны хүрээнд 1 зөрчлийг илрүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Хар тамхи, мөнгө угаах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 93.3% | 100% | - Тайлант хугацаанд Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар хороодод Дэлхийн гаалийн байгууллага (WCO)-ын Бүс нутгийн зөрчлийн мэдээлэл солилцох төв [redacted]өөс Зөрчлийн мэдээллийн сүлжээ [redacted]ээр ирүүлсэн Ази номхон далайн бүс нутаг ([redacted])-ийн гаалийн байгууллагуудын 2024 онд илрүүлсэн хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараатай холбоотой 2024 оны зөрчлийн мэдээллийг зурагт танилцуулга байдлаар нэгтгэж мэдээллийг 37 удаа [redacted] дотоод сүлжээнд байршуулж, харьяа гаалийн 18 газар хороодод спаркаар мэдэгдсэн;<br>- Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 9-ний өдрийн [redacted] тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний Зорилго [redacted] (Терроризмыг санхүүжүүлэх, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлж болзошгүй үйлдлийг таних, Мөнгө угаах үйлдлийг илрүүлэх ажиллагааг сайжруулах)-ын [redacted] дахь ажил (Гаалийн ерөнхий газрын орон тооны бүтцэд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэл хариуцсан алба хаагч [redacted] багагүй, хилийн боомтуудад [redacted] багагүй байхаар зохицуулалт хийж, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, гаалийн хяналтын техник, тоног төхөөрөмжийг сайжруулах)-ын хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэл хариуцсан нэг албан тушаалтныг харьяа гаалийн газар, хороодын даргын тушаалаар тус бүр томилж, мэдээллийг ирүүлэх тухай ГЕГ-ын дэд дарга бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн [redacted] даргын гарын үсэгтэй 2024.03.22-ны өдрийн [redacted] албан | 2024.01.01-2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичгийг харьяа гаалийн 18 газар хороодод хавсралтаар хүргүүлсэн;<br>- МУГХУСАЗЗ-ийн ажлын албаны 2024.04.04-ний өдрийн [redacted] тоот албан бичгээр ирүүлсэн Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг Чиглэл хүргүүлэх тухай албан бичгээр харьяа гаалийн газар, хороодод хүргүүлэв. Дээрх ажлын төлөвлөгөөний биелэлтийг хангаж хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой “Байгалиа хамгаалъя” сургалт мэдээллийн ажлыг харьяа гаалийн газар, хороодод зохион байгуулж, биелэлтийн тайланг холбогдох хуулийн байгууллага (МУГХУСАЗЗ)-д ГЕГ-ын 2024.05.22-ны өдрийн [redacted] албан бичгээр хүргүүлсэн.<br>- Бэлэн мөнгө /валют/-ийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, гаалийн хяналтаас нуун далдлах, Монгол Улсын иргэд гадаадын орны гаалийн нутаг дэвсгэрт санаатай болон санамсаргүй байдлаар хэрэг, зөрчилд холбогдох нөхцөл байдал хил орчмын бүс нутагт гарч байгаа талаар урьдчилан сэргийлэх талаар Чиглэл хүргүүлэх тухай албан бичгийг ГЕГ-ын 2024.05.27-ны өдрийн [redacted] тоот албан бичгээр харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн.<br>- ДГБ-ын гишүүн орнуудад бүртгэгдсэн мэдээллээр гарал үүсэл нь тодорхойгүй, сав, баглаа, боодол, шошго дээрх мэдээлэл буруу, үйлдвэрийн бус аргаар савласан, барааны тэмдэг хуурамч, зохиогчийн эрхийг зөрчсөн хуурамч барааны хууль бус эргэлт нэмэгдэж, хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талаар мэдээлж байгаа талаар, мөн зөрчилд холбогдсон барааны хувьд ихэвчлэн хилээр нэвтрүүлэхэд тарифын бус хязгаарлалт тогтоосон бараа /эм, эмнэлгийн хэрэгсэл, архи, согтууруулах ундаа, янжуур тамхи, химийн бодис/, тээврийн хэрэгсэл болон машин механизм, тоног төхөөрөмжийн сэлбэг, эд анги/, гоо сайхны болон тансаг хэрэглээний бараа /сүрчиг, ингэсэг, бугуйн цаг, гар утас, электрон бараа/, хүүхдийн тоглоом, ахуйн болон өргөн хэрэглээний бараа /хувцас, гутал/ бүртгэгдсэн байгаа талаар Чиглэл хүргүүлэх тухай албан бичгийг ГЕГ-ын 2024.05.22-ны өдрийн [redacted] тоот албан бичгээр харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн.<br>- Дэлхийн дулаарал, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протоколоор олон улсын хяналтад орсон химийн бодис Ozone Depleting Substances (ODS), Гидро Флюорокарбон (HFCs), Гидрофтор нүүрстөрөгч (HFCs) болон Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенцоор олон улсын хяналтад орсон хуванцар хог хаягдал (plastic waste), цахилгаан, электроник тоног төхөөрөмжийн хог хаягдал (e-waste)-ийг агаараар, далайгаар, эх газраар тээвэрлэж хилээр хууль бусаар нэвтрүүлэх зөрчлийн чиг хандлага Ази, номхон далайн бүс нутгийн бүс нутаг дахь зөрчлийн талаар харьяа гаалийн газар, хороодод мэдээлэл зөвлөмж хүргүүлэх тухай ГЕГ-ын 2024.07.17-ны өдрийн [redacted] албан бичгээр хүргүүлсэн.<br>- Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протоколоор олон улсын хяналтад орсон химийн бодис Ozone Depleting Substances (ODS), Гидро Флюорокарбон (HFCs), Гидрофтор нүүрстөрөгч (HFCs) болон Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенцоор олон улсын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хяналтад орсон хуванцар хог хаягдал (plastic waste), цахилгаан, электроник тоног төхөөрөмжийн хог хаягдал (e-waste)-тай холбоотой [redacted] Сэрэмжлүүлэг мэдээллийг орчуулж [redacted] дотоод сүлжээнд 2024 оны 6 дугаар сараас 10 дугаар сар хүртэл 4 сарын хугацаанд байршуулсан.<br>- Олон улсын валютын сан (IMF)-аас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр сургалтыг Улаанбаатар хотноо 2024 оны 4 дүгээр сарын 8-наас 10-ны өдрүүдэд танхимын хэлбэрээр "Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах дэвшилтэт арга, техник" сэдэвт сургалтыг ГЕГ болон ЦЕГ, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албатай хамтран ГЕГ-ын аль 9 давхарын хурлын зааланд ГЕГ-ын бүтцийн нэгжүүд болон харьяа 15 гаалийн газруудын 50 чиглэл хариуцсан албан хаагч нарт амжилтай зохион байгуулсан.<br>- ГЕГ-ын ОНХА-тай хамтран Гаалийн ерөнхий газрын www.customs.gov.mn цахим хуудасны Гаалийн хяналт бүрдүүлэлт, зөрчил цэсний Зөрчил хэсэгт Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр "Бусдын дайвар ачаа авахаас татгалзах" тухай сэрэмжлүүлэг, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх улсын хилээр бэлэн мөнгө (валют)-ийг нэвтрүүлэхэд анхаарах" асуудлын талаар сэрэмжлүүлэг мэдээ бэлтгэн хүргэсэн. 2024 оны 12 дугаар сард багтааж нэгжүүдийн хуваарийн дагуу Монголын гааль цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээхэд бэлэн болсон.<br>- Монголын Үндэсний олон нийтийн телевизтэй хамтран хувийн болон албаны ажлаар гадаад улсад зорчихдоо бусдаас дайвар ачаа авахгүй байх тухайн дайвар ачаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, МУ-ын эмийн жагсаалтад | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэлгүй эм, тариа зэрэг хориглосон, хязгаарласан бараа байгаа тохиолдолд тухайн хүн өөрөө хуулийн хариуцлага хүлээх тухай анхааруулга мэдээллийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөрөөр дамжуулан олон нийтэд хүргэсэн.<br>- Хамтын ажиллагааны хүрээнд ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газарт ашиглагдаж байсан "Body scan" буюу зорчигчийн биед биет үзлэг хийх зориулалт бүхий тоног төхөөрөмжийг ЧХОУНБ-ын зорчигчийн ирэх талд 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр суурилуулан гаалийн хяналт шалгалтад ашиглаж байна. ЧХОУНБ-ын зорчигчийн ирэх талд зорчигчийн биед үзлэг хийх тоног төхөөрөмж нь эвдэрсэн байсан ба олон улсын ирэх чиглэлийн зорчигчид хяналт, шалгалтыг бүрэн тавих боломжгүй байсан. Мөн уг арга хэмжээг МҮОНРТ сурвалжилж олон нийтэд түгээснээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг биедээ нууж улсын хилээр нэвтрүүлэх боломжгүй болж байна гэх урьдчилан сэргийлэх, анхааруулга мэдээллийг нийтэд түгээсэн.<br>- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тандан илрүүлэгч [redacted] гар багажийн ашиглалтын талаарх дэлгэрэнгүй сургалтыг Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газрын Зөрчилтэй тэмцэх албанд 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан бөгөөд 4 зөрчилтэй тэмцэх чиглэл хариуцсан алба хаагч хамрагдсан.<br>- Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Гаалийн ерөнхий газрын харьяа газар, хороодын Эм био бэлдмэлийн болон хорт болон аюултай бодисын хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах зорилгоор VR (Virtual Reality) технологид суурилсан "Видео сургалтын багц модуль"-ын Хар тамхи модуль болон "Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхээр завдсан гэмт хэргийн нөхцөл байдал, арга хэлбэр буюу түүнтэй тэмцэх нь” сэдвээр 2024 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр сургалт зохион байгуулсан бөгөөд 30 алба хаагч сургалтад хамрагдсан.<br>- Гаалийн ерөнхий газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн дарга, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын Эрүүгийн цагдаагийн хэлтсийн дарга нарын 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр хамтран баталсан [redacted] арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөний хүрээнд Гаалийн ерөнхий газрын Эрэлч нохойн сургалтын төв, Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газрын харьяа “Монгол шуудан-Хөшгийн хөндий”, “Монгол шуудан ХК”, “Ди Эйч Эл”, “Монгол шуудан-Нисэх”, “Монгол Инфинити шуудан” гаалийн хяналтын бүсүүдэд 2024 оны 10 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд сургалт зохион байгуулсан. [redacted] бодисын тухай 1971 оны конвенцын хавсралтад багтсан [redacted], [redacted], [redacted] зэрэг бодисуудыг алба хаагчдад бодитоор харуулах, рентген төхөөрөмжөөр оруулан өнгөний ялгарлыг үзүүлэх, албаны эрэлч нохойнд бодит бодисын үнэрийг таниулах чиглэлээр сургалтыг зохион байгуулсан бөгөөд Эрэлч нохойн сургалтын төв, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын нийт 42 алба хаагч хамрагдсан.<br>- “Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхээр завдсан гэмт хэргийн нөхцөл байдал, арга хэлбэр буюу түүнтэй тэмцэх нь”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг [redacted] хяналтаар таньж илрүүлэх аргачлал” | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэдэвт сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Ховд аймгийн Булган дахь гаалийн газар, Увс аймаг дахь гаалийн газар, Говь-Алтай аймгийн Бургастай дахь гаалийн хороо, Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хороонд, 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Дорнод аймаг дахь гаалийн газар, Орхон аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Дархан-Уул аймаг гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газар, Шивээхүрэн дэх гаалийн газар, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар, Хөвсгөл аймгийн Ханх дахь гаалийн хороонд 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хотын гаалийн газар, Ханги дахь гаалийн газарт, 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт цахимаар, 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Гаалийн ерөнхий газрын Зохион байгуулалтын нэгж, дэргэдэх байгууллагын алба хаагчдад, 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт, 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Замын-Үүд дэх гаалийн газарт, 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газарт танхимаар зохион байгуулсан бөгөөд сургалтад нийт 721 алба хаагч хамрагдсан. Мөн тусгай шалгалтад тэнцэж, болзол шалгуурыг хангаж Гаалийн ерөнхий газар болон харьяа газар, хороодод томилогдох 37, өөр бусад төрийн байгууллагаас сэлгэн ажиллахаар ирсэн 18 алба хаагчид 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр дээрх сургалтыг орсон.<br>- Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанаас ирүүлсэн 2024.03.25-ны өдрийн [redacted] албан хүсэлтийн дагуу "Гаалийн бүрдүүлэлт, горим, эрсдлийн удирдалга, мөнгө угаахтай тэмцэх" чиглэлээр гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаар Монголбанкны дэргэдэх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Санхүүгийн мэдээллийн албаны албан хаагч нарт Монголбанкны [redacted] байрны сургалтын танхимд Монголбанкны СМА-ын 15 ажилтанд сургалт зохион байгуулсан.<br>- Дэлхийн гаалийн байгууллага (WCO), Дэлхийн шуудан холбоо (UPU)-ны хамтарсан [redacted] ын төслийн хүрээнд Монгол Улсын Гаалийн-шуудангийн хамтын ажиллагааны хүрээнд Гаалийн ерөнхий газрын харьяа Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын гаалийн болон шуудангийн албан хаагч нарт Синтетик төрлийн хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисын олон улсын нөхцөл байдал, чиг хандлага, гаалийн хяналтаас нуун далдлах арга хэлбэр, анхаарах асуудлууд зэрэг сэдвээр 2 хоногийн сургалт явуулсан.<br>- Бүрдүүлэлтийн цахим төвийн албан хаагч нарт Озоны үндэсний албан, Экологийн цагдаагийн байгууллага, ГЕГ-ын Сургалтын төв, ГЕГ-ын ЗТГ хамтран дараах сургалтыг зохион байгуулсан:<br>- "Монреалийн Протоколоор олон улсын хяналтад орсон Химийн бодис (ODS), Гидрофтор нүүрстөрөгч (HFCs) болон бусад хууль бусаар хил дамжуулан худалдаалагдаж болзошгүй аюултай бодисын олон улсын нөхцөл байдал, Гаалийн байгууллагын анхаарах асуудлууд" сэдвээр Озоны үндэсний алба;<br>- "Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, Гаалийн байгууллагын анхаарах асуудлууд" сэдвээр Экологийн цагдаагийн алба;<br>- "Озон задалдаг бодис болон тэдгээрийг орлуулах бодисуудын барааны ангиллыг тодорхойлох" сэдвээр Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Сургалтын төв;<br>- "Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай базелийн конвенцоор олон улсын хяналтад орсон хуванцар хог хаягдал (plastic waste), цахилгаан, электроник тоног төхөөрөмжийн хог хаягдал (e-waste)" | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэдвээр Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс<br>- Монголбанкны санхүүгийн мэдээллийн албатай хамтран 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгжүүдийн нийт албан хаагч нарт "Олон улсад үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотойгоор гаалийн байгууллагын анхаарах асуудлаар", "Хоёрдмол зориулалттай бараа" сэдвийн хүрээнд Гаалийн байгууллагын "Мэдээллийн цаг"-аар сургалт мэдээлэл зохион байгуулсан. ГЕГ-ын 60 гаруй алба хаагч хамрагдсан.<br>- Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хороодод цахим хэлбэрээр 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр "Олон улсад үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотойгоор гаалийн байгууллагын анхаарах асуудлаар", "Хоёрдмол зориулалттай бараа" сэдвийн хүрээнд цахим сургалтыг зохион байгуулж 19 газар хороодын 600 орчим алба хаагч хамрагдсан.<br>- Эрсдэл өндөртэй, зам суваг тогтоогдсон гаалийн газар хороодыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх багаж тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд зарим газар хороодод бүртгэлтэй багажуудыг шилжүүлэх ажлыг ГЕГ-ын даргад танилцуулж СХОГ-тай хамтран шийдвэрлэсэн. Үүнд: [redacted] багажийг [redacted] ашиглагдаж байсан [redacted] багажийг [redacted] тус тус шилжүүлэх тухай ГЕГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн [redacted] дугаартай тушаал гаргуулсан.<br>- Ашиглалтын үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйн улмаас ашиглах боломжгүй байсан ЗҮГГ, УХШИГГ-т тус тус бүртгэлтэй [redacted] багажийг татан авчирч шаардагдах засвар үйлчилгээний зардлыг Ач сервис ХХК-р гаргуулж СХОГ-т хүргүүлээд байна. Тус багажуудыг ЗҮГГ, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ЧХОУНБГГ-уудад хуваарилах, тус газруудын 2025 оны төсөвт засвар үйлчилгээний зардлыг тусгаж шийдвэрлэх асуудлыг мөн ГЕГ-ын даргад танилцуулсны дагуу шийдвэрлэж 2025 оны эхний улиралд багтаан ашиглалтад оруулж хяналт, шалгалтад ашиглахаар болсон.<br>- Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан бараа, бэлэн мөнгө түүнтэй адилтгах хэрэгсэл, түүх соёлын дурсгалт зүйлсийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Чингис Хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын гаалийн хяналтын бүсийн камерын судалгааг гаргах, нэмэлтээр камер суурилуулах шаардлагатай камерт өртдөггүй эрсдэл өндөртэй цэгүүдийг тогтоох зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ажиллаж тус газрын хяналтын камерын дэлгэрэнгүй судалгааг боловсруулж удирдлагад танилцуулсан. ГЕГ-ын дэргэдэх Шуурхай хяналтын төвтэй хамтран 2025 оны эхний улиралд багтааж шаардлагатай камерыг суурилуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>- Мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлтийг эрчимжүүлэх зорилгоор Гаалийн автоматжуулсан удирдлагын систем [redacted] гийн мэдээллийг шинэчлэх, тус санг баяжуулах зорилгоор 2021 оноос хойших хугацаанд Монгол Улсын [redacted] холбогдож байсан эсхүл [redacted] санд зайлшгүй оруулах шаардлагатай гэх иргэдийн мэдээллийг авахаар [redacted] газруудад албан бичиг хүргүүлсэн. Хэлтсийн үйл ажиллагаанаас үл хамааран хойшлогдсон 2025 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны эхний улиралд багтаан шинэчлэл хийхээр төлөвлөж байна.<br>- Гаалийн байгууллагын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор шинээр багаж тоног төхөөрөмж авах шаардлагатай эсэхийг тогтоох ажлын хүрээнд байгууллагын хэмжээнд ашиглагдаж буй багажийн судалгааг боловсруулж ГЕГ-ын дарга, ЗТГ-ын дарга нарт танилцуулсан. Шинээр худалдаж авах шаардлагатай багажийн судалгааг гаргаж ХБГ, СХОГ-т тус тус хүргүүлсэн. | | |
| 4. | Мэдээллийн санд мөнгө угаах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой дүн шинжилгээ хийсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 90% | 100% | - Тайлант хугацаанд Монгол Улсад бүртгэгдээгүй 2 төрлийн мансууруулах төрлийн сэтгэцэд нөлөөт бодис илэрсэн ба гаалийн газар, хороодод ажиллаж байгаа алба хаагч нарт 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хооронд 8 удаа шинэ төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис /тухайлбал [redacted], [redacted]-ыг таних, хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлтийг эрчимжүүлэхэд алба хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах дадлага, сургалтыг 801 төрийн тусгай алба хаагчдад орсон.<br>- “Синтетик төрлийн хар тамхины ОУ-ын шуудан илгээмж дэх хууль бус эргэлтийг илрүүлэх чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор ДГБ-ын экспертүүд УХШИГГ-т ажиллах болсонтой холбогдуулан мансууруулах эи, сэтгэцэд нөлөөт бодисыг улс хоорондын шуудан илгээмж ашиглан улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан хэрэг зөрчлийн 2018-2023 оны мэдээлэлд дүн шинжилгээ хийж Гаалийн ерөнхий газрын даргад танилцуулсны ДГБ-ын экспертүүд Улс хоорондын шуудан илгээмж дэх гаалийн газарт ажиллах шаардлагатай гэж үзээд олон улсын шуудан илгээмжээр улсын хилээр хууль | 2024.01.01-2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх чиглэлд заавар, зөвлөмж авах үндэслэл болсон.<br>- [redacted] мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын гадаад, дотоод нөхцөл байдлын мэдээллийг [redacted] 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн [redacted] албан бичиг, [redacted] газрын 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн [redacted] тоот албан бичгээр тус тус авч нэгтгэн дүн шинжилгээ хийж ГЕГ-ын дарга, дэд дарга, ГЕГ-ын Хяналт бүрдүүлэлтийн газар, Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар, Эрсдэлийн удирдлагын хэлтэст 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр [redacted] тоот дотоод зурвасаар, ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодод 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн [redacted]от албан бичгээр албан хэрэгцээнд ашиглахаар хүргүүлсэн.<br>- Карго ачаанд хар тамхи, мансууруулах бодисыг нуувч болгон ашиглаж улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдаж байж болзошгүй гэж үзэн [redacted]сүүлийн 3 жилд импортолсон барааны гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж түүний үр дүнд УБГГ, ЗҮГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ-ын зөрчилтэй тэмцэх албыг мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажиллаж 2024 оны 06, 07, 08, 10-р сарууд 4 удаагийн онилгоо дахин шалгалтыг хийгээд байна.<br>- Бэлэн мөнгөтэй холбоотой дүн шинжилгээ судалгааг 2022-2024 он хамаарах байдлаар хийж ГЕГ-ын удирдлагыг мэдээллээр хангаж, гаалийн газар хороодыг удирдлага арга зүйгээр хангаж ажилласан. Үүнд:<br>  - Гаалийн байгууллагад 2022, 2023 болон 2024 оны эхний хагас, бүтэн жилийн байдлаар мэдүүлсэн, валют, бэлэн мөнгөний мэдээлэлд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тоо, чанарын үзүүлэлтээр хийсэн судалгаа, дүн шинжилгээ<br>- 2022-2024 оны эхний хагас жилд илрүүлсэн бэлэн мөнгө /валют/-тай холбоотой хэрэг зөрчлийн харьцуулсан дүн шинжилгээ. | | |
| 5. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | - Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд "Хүрээлэн буй орчны эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх" чиглэлээр 2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Гаалийн байгууллагын саналыг хүргүүлэн биелэлтийг ханган ажиллаж 2024 оны хагас, бүтэн жилийн хэрэгжүүлсэн ажлын тайланг хугацаанд хүргүүлсэн.<br>- Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх" чиглэлээр 2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Гаалийн байгууллагын саналыг хүргүүлэн 2024 оны хагас, бүтэн жилээр хэрэгжүүлсэн ажлын тайланг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн.<br>- Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд "Гаалийн ерөнхий газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2023 онд хийсэн ажлын гүйцэтгэлийн тайлан"-г хүргүүлж 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулах саналыг хүргүүлж биелэлтийг ханган ажиллаж байна. 2024 оны хагас жил хэрэгжүүлсэн ажлын тайланг хүргүүлсэн ба жилийн эцсийн тайланг хүргүүлэхээр боловсруулаад байна.<br>- "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2023 оны төлөвлөгөөний биелэлт, тайлан"-г хүргүүлж 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгуулах саналыг хүргүүлсэн биелэлийг ханган ажиллаж 2024 оны хагас жилийн байдлаар хэрэгжүүлсэн ажлын тайланг хүргүүлсэн, жилийн эцсийн тайланг хүргүүлэхэд бэлэн болгож боловсруулаад байна. | 2024.01.01-2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - "Үндэсний аюулгүй байдлын зөвлөл"-ийн 2018 оны зөвлөмжийн биелэлт болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр 2018-2023 оны хооронд Гаалийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, санал, дүгнэлтийг багтаасан [redacted] хуудас бүхий танилцуулга бэлтгэж 2024 оны [redacted] сарын [redacted] өдрийн [redacted] дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хууль сахиулах төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны танилцуулга, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Хууль зүй дотоод хэргийн сайд бөгөөд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны даргад хүргүүлсэн.<br>- Гаалийн ерөнхий газрын 2024 оны "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний биелэлтийн тайланд нэгжийн чиг үүрэгт хамаарах ажлын тайланг гаргаж хүргүүлэхэд бэлэн болгож боловсруулж дууссан. | | |
| 6. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 80% | 100% | - Мөнгө угаах, хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотойгоор харьяа гаалийн газар, хороодыг цаг тухай бүрд холбогдох хууль тогтоомж (жишээлбэл: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Зөрчлийн тухай, Гаалийн тухай хууль г.м)-ийн дагуу заавар, зөвлөмж, удирдамжаар ханган ажилласан. Үүний хүрээнд хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан 14 удаагийн үйлдлийг таслан зогсоож, | 2024.01.01-2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ээн холбогдогч болон нотлох баримтын хамт эрх бүхий байгууллагуудад харьяаллын дагуу шилжүүлэн өгсөн.<br>- "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хууль"-ийг шинэчлэн боловсруулж батлуулах ажлын хэсэгт орж ажиллан гаалийн байгууллагын хариуцан хэрэгжүүлэх чиглэлд санал хүргүүлж ажилласан.<br>- Монгол Улсын Ерөнхий Сайдын 2023 оны [redacted] дүгээр сарын [redacted] Захирамж, Монгол Улсын Терроризмтой тэмцэх зөвлөлийн даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн "Экспортын хяналтын тухай хууль боловсруулах дэд ажлын хэсэг байгуулах тухай" [redacted] дугаартай тушаалын хүүлбар, Хуулийн төслийн үзэл баримтлал, Танилцуулга, Хуулийн төслийг тус тус хавсралтаар ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагад дотоор зурвасаар хүргүүлж, санал хүсэлтийг ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлж, хуулийн төсөлд гаалийн байгууллагаас тусгах, саналуудыг нэгтгэх ажил хийгдэж байна. Тус хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Гаалийн ерөнхий газрын "Санал хүргүүлэх тухай" 2024 оны [redacted] дугаар сарын [redacted] өдрийн [redacted] тоот албан бичгийн хавсралтаар тус хуулийн төсөлд тусгуулах холбогдох саналыг Терроризмтой тэмцэх зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн. Тус хуулийн төсөлтэй холбоотой Ажлын хэсгийн ойрын хугацаанд зарлагдаж, хуралдахаар төлөвлөж буй дэд ажлын хэсгийн хурлал Хамтын ажиллагааны гишүүн байгууллагын хувьд Гаалийн байгууллагаас томилогдсон албан хаагчийг оролцуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны [redacted] дугаар сарын [redacted] өдрийн [redacted]Хяналт, шалгалтын ажлыг эрчимжүүлэх тусгайлсан төлөвлөгөө"-г батлаж, Гаалийн ерөнхий газар, түүний зохион байгуулаалтын бүтцийн нэгжүүд, харьяа Гаалийн газар, хороодын хэмжээнд хэрэгжилтийг хангаж дараах ажлуудыг хэрэгжүүлж байна:<br>- Хилийн боомт дахь гаалийн хяналт, шалгалтыг сайжруулах ажлын хүрээнд Хоёрдмол зорилгоор ашиглагдаж болзошгүй зарим төрлийн бараанд тавих гаалийн хяналтыг тусгайлан сайжруулах, аливаа зөрчил, эрсдэл гэх үндэслэлтэй бол бараа, эд зүйлсийг шалгалтад хамруулах, барааны гарал үүслийг өөрчлөж гаалийн байгууллагад мэдүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гаалийн хяналт шалгалт, бичиг баримтын бүрдүүлэлтийг сайжруулах;<br>- Зөрчилтэй тэмцэх чиглэлийн хүрээнд Хоёрдмол зорилгоор ашиглагдаж болзошгүй бараа, бүтээгдэхүүнтэй холбоотой зөрчил үйлдэгдсэн, илэрсэн тухай бүр Гаалийн ерөнхий газрын холбогдох нэгжид мэдэгдэж, чиглэл зөвлөмж авч ажиллах;<br>- Эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон сургалт мэдээллийн ажил зохион байгуулах чиглэлээр эрсдэлийг онилох шалгуур үзүүлэлт тодорхойлох, эрсдэл тооцох арга, аргачлал боловсруулах, гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааны явцад анхаарах асуудлыг тодорхойлох, сургалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлсэн.<br>- Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх Үндэсний зөвлөлийн гишүүн ГЕГ-ын дэд даргын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гадаад болон дотоод хурал, семинарт оролцох бэлтгэл ажлын хүрээнд энэ чиглэлээр гаалийн байгууллагын хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаар танилцуулга мэдээллийг бэлтгэсэн.<br>- Гаалийн байгууллагын Бэлэн мөнгөний бүртгэлийн санд бүртгэгдэх валютын мэдээллийг монгол төгрөгөөр илэрхийлэгдэх дүнг гаргах програмын өөрчлөлт оруулах санал, хүсэлтийг ГЕГ-ын МТГ-т хүргүүлж шийдвэрлүүлсэн.<br>- ГЕГ-ын ЗББНДБ-аас холбогдох хууль тогтоомжийг шинэчлэхтэй холбоотой 15 удаагийн санал авах дотоод зурвас, хууль журмын төсөлтэй танилцаж тус нэгжээс тусгах саналыг хүргүүлсэн. | | |
| 7. | Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 0% | 100% | Нэгжийн үйл ажиллагаанд дараах хоёр төрлийн эрсдэл учирч болзошгүй гэж тодорхойлон шаардлагатай хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.<br>1. Алба хаагчдын аюулгүй байдал<br>Тус нэгжийн алба хаагчид шөнө оройн /олон улсын нислэгийн цагаас хамаарч/ цагаар ихэвчлэн давхар хяналт, шалгалтыг хэрэгжүүлэн ажилладаг ба энэ үед алба хаагчдыг баталгаатай тээврийн хэрэгслээр зорчуулах ажлыг хэрэгжүүлэх үүднээс ЗТГ-ын даргад танилцуулга хүргүүлж алба хаагчдыг гаалийн газар хороодод зорчихдоо заавал албаны унаагаар, ААҮА-ны жолоочтой зорчиж байхаар шийдвэрлэж, тухай бүрт ААҮА-нд мэдэгдэхгүйгээр жолоочийг урьдчилан бэлдүүлэх, шатахууны зардлыг дараа нөхөн гаргуулж болохоор шийдвэрлэгдсэн. /ААҮА-д машин болон шатахуун авах асуудлыг урьдчилж мэдэгдэх тохиолдолд мэдээлэл задарч болзошгүй гэж үзэн зарим тохиолдолд хувийн унаагаар зорчдог байсан./<br>2. Мэдээллийн аюулгүй байдал<br>Олон улсын шуудан илгээмжээр ирүүлсэн мансууруулах бодисыг Цагдаа, тагнуулын байгууллагатай хамтран хяналтад хүргэх ажиллагаа | 2024.01.01-2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хийх үед мэдээлэл задрах тохиолдол гарч байсан тул бусад хууль хяналтын байгууллагуудтай тохирсны хүрээнд тус ажиллагаанд оролцож байгаа болон шуудан илгээмжийн үйл ажиллагаа эрхэлдэг [redacted] бусад [redacted] гаргуулж авдаг болсноор мэдээлэл задрах эрсдэлийг бууруулсан. | | |
| 8. | Үүрэг даалгаврынбиелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | ГЕГ-ын ЗУГ-ын даргаас тайлант хугацаанд өгсөн дараах 10 үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлж ЗДАС программын "Үүрэг даалгавар" хэсэгт хаалтыг хийж ажилласан.<br>- 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг ашиглах, хэрэглэхтэй холбоотой зөрчлүүд сүүлийн үед ихээр гарч байгаа тул Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны [redacted] дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх журам"-ын хэрэгжилтийг хангах,<br>- 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн ГЕГ-ын даргын 2022 оны [redacted] дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.13 дахь заалтыг үндэслэн нийт ажилтан, албан хаагчдад зориулсан "Мэдээллийн цаг"-ийг 14 хоног тутамд 1 удаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. 2024 оны эхний мэдээллийн цагийг 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 09.00 цагт зохион байгуулсан бөгөөд ирцийн байдал хангалтгүй байна. Иймд "Үүрэг даалгавар"-ын программаар улирал бүр нийт албан хаагчдын мэдээллийн цагт хамрагдсан байдлыг харгалзан үзэж, дүгнэхээр болсон тул албан хаагчдаа бүрэн идэвхтэй хамруулж ажиллахыг үүрэг болгож байна,<br>- 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Гаалийн байгууллагаас 2024 онд дэвшүүлсэн "Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, хамтын ажиллагааг | 2024.01.01-2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өргөжүүлэх", "Цахим шинэчлэлд суурилсан ил тод, шуурхай төрийн хяналтыг хэрэгжүүлэх", "Мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлж, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бий болгох" зорилтуудын хүрээнд Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/69 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт", 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ыг нийт албан хаагчиддаа танилцуулах ажлыг шуурхай зохион байгуулж, хавсралтаар хүргүүлсэн хүснэгтийн дагуу гарын үсгээр баталгаажуулан 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн дотор ирүүлэх, мөн журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгож байна гэх үүрэг даалгаварыг тус тус бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна<br>- 2024 оны 04 дүгээр сарын 01-ний "Үүрэг даалгавар"-ын программаар улирал бүр нийт албан хаагчдын мэдээллийн цагт хамрагдсан байдлыг хяргалзан үзэж, дүгнэхээр болсон тул албан хаагчдаа бүрэн идэвхтэй хамруулж ажиллахыг үүрэг болгож байна. Биелэлт: Мэдээллийн цаг зарлагдах бүрд албан хаагчдыг мэдээллийн цагт хамрагдах шаардлагыг тавьдаг ба нэгжийн ажлын чиг үүргийн хүрээнд харьяа гаалийн газар хороодын гаалийн хяналтын бүсэд ажиллаж байгаа тохиолдолд шалтгааныг хэлж бүртгүүлэн ажиллаж байна.<br>- 2024 оны 08 сарын 05-ны Гаалийн Захиргаа, дотоод ажлын систем программын "ГААЛЬ СУДЛАЛ" дэд талбарын "Бусад" ангилалд ДГБ-ын "Байгууллагын Жендэрийн эрх тэгш болон ялгаатай байдлыг үнэлэх заавар" болон энэ талаарх танилцуулга (ДГБ-ын Жендэрийн эрх тэгш болон ялгаатай байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого чиглэл, арга хэрэгсэл, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монголын Гаалийн ажлын хэсгийн ажиллах зарчим, цаашид анхаарах асуудал)-ыг байршуулсан болно. Иймд Та бүхэн дээрх мэдээллийг хүлээн авч, ялангуяа гаалийн газар, хорооны удирдлагууд анхааралдаа авч албан хаагч нарт танилцуулан, 2024.08.30-ны өдөр товч хэлбэрээр биелэлтийг (Танилцуулсан арга хэлбэр, хүний тоо, хариуцах албан хаагч) Ёс зүйн дэд хороонд ирүүлнэ үү. Биелэлт: Байгууллагын Жендэрийн эрх тэгш болон ялгаатай байдлыг үнэлэх заавар" болон энэ талаарх танилцуулгыг 2024 оны 09-р сарын 16-ны өдрийн хэлтсийн хурал дээр ГУАБ 1, ГУБ 5 нийт 6 албан хаагчдад танилцуулж, судлах чиглэл өгсөн.<br>- "Синтетик төрлийн хар тамхины ОУ-ын шуудан илгээмж дэх хууль бус эргэлтийг илрүүлэх чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр ДГБ-ын экспертүүд ажиллах болсонтой холбогдуулан Улс хоорондын шуудан илгээмж ашиглан улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан хэрэг зөрчлийн 2018-2023 оны мэдээлэлд дүн шинжилгээ хийж ГЕГ-ын даргад танилцуулсан.<br>- ГЕГ-ын дэд дарга Г.Энхтайван ОХУ-ын Москва хотноо зохион байгуулагдсан олон улсын форумд оролцохтой холбоотойгоор тус нэгжийн чиг үүргийн хүрээнд хариуцан хэрэгжүүлж буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой хэрэг зөрчлийг агуулсан танилцуулга бэлтгэж хүргүүлсэн.<br>- Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хороодын хуваарийг цахим болгох тухай Мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны [redacted] дугаартай шийдвэрийн дагуу "Цахим хуваарилалтын систем"-ыг нэвтрүүлэх ажлын хэсэгт орж ажиллан, 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс УБГГ, ЗҮГГ-ын хуваарийг цахимд шилжүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан бараа, бэлэн мөнгө түүнтэй адилтгах хэрэгсэл, түүх соёлын дурсгалт зүйлсийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Чингис Хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын гаалийн хяналтын бүсийн камерын судалгааг гаргах, нэмэлтээр камер суурилуулах шаардлагатай камерт өртдөггүй эрсдэл өндөртэй цэгүүдийг тогтоох зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ажиллаж тус газрын хяналтын камерын дэлгэрэнгүй судалгааг боловсруулж удирдлагад танилцуулсан. ГЕГ-ын дэргэдэх Шуурхай хяналтын төвтэй хамтран 2025 оны эхний улиралд багтааж шаардлагатай камерыг суурилуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br>- Орос, Украйны дайнтай холбоотойгоор олон улсаас ОХУ-д авч хэрэгжүүлж буй эдийн засгийн болон бусад хориг арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэж хүргүүлсэн.<br>- Гадаад улсад зохион байгуулагдах арга хэмжээнд алба хаагчийн нэр хүргүүлэхтэй холбоотойгоор тус зохион байгуулагдах арга хэмжээний ерөнхий танилцуулга, ач холбогдол зэргийг багтаасан 4 удаагийн гадаад арга хэмжээний танилцуулгыг боловсруулж ГЕГ-ын даргад хүргүүлсэн.<br>- Байгууллагын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор шинээр багаж тоног төхөөрөмж авах шаардлагатай эсэхийг тогтоох ажлын хүрээнд байгууллагын хэмжээнд ашиглагдаж буй багажийн судалгааг боловсруулж ГЕГ-ын дарга, ЗТГ-ын дарга нарт танилцуулсан.<br>- Хар тамхи, мансууруулах бодис болон Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдах тохиолдол өсөн нэмэгдэх хандлагатай байх тул | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дараах ажлын чиглэлийг гаалийн газар, хороодод хүргүүлэн ажиллаа. Үүнд:<br>- [redacted]сейфтэй болох;<br>- Нарийн хэмжилт хийдэг баталгаат жинтэй болох чиглэлийг ЧХОУНБГГ, УХШИГГ-т;<br>- Хар тамхитай тэмцэх чиглэл хариуцсан холбоо баригч томилж, нэр, холбоо барих утасны дугаарыг ирүүлэх чиглэлийг ЧХОУНБГГ, УХШИГГ, ЗҮГГ, СЭГГ-т;<br>- Сар бүрийн 05-ны өдрийн дотор хавсралтаар хүргүүлсэн Мэдээлэл авах хүснэгтийн дагуу хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан гэмт хэрэг, зөрчлийн талаарх тайланг ирүүлж байх чиглэлийг ЧХОУНБГГ, УХШИГГ, ЗҮГГ, СЭГГ-т;<br>- Зорчигчийн хувийн хэрэглээний эмийг гаалийн хилээр нэвтрүүлэх үед Гаалийн тухай хуулийн 227 дугаар зүйл болон Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам"-ыг удирдлага болгон, мөрдөж ажиллах.<br>- Мөн хар тамхи, мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодис, эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан гэмт хэрэг, зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэхдээ Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газар, Олон нийттэй харилцах албанаас чиглэл авч байхыг үүрэг болгосон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газарт Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнтэй холбоотой зөрчлийн хэрэг бүртгэлтэд зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах тухай ажлын чиглэлийг хүргүүлсэн.<br>- "Хөрөнгө хуваарилах тухай" Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны [redacted] сарын [redacted] ний өдрийн [redacted] дугаартай тушаал гарсантай холбогдуулан тус газруудад шилжүүлж буй багаж тоног төхөөрөмжийг шийлжүүлэн авч үйл ажиллагаанд ашиглаж, ашиглалтын тайлан мэдээг сар бүр ирүүлж байх тухай чиглэлийг ЧХОУНБГГ, СЭГГ-т тус тус хүргүүлсэн. | | |
| 9. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 90% | 100% | Хөдөлмөрийн дотоод журмын дагуу нэгжийн бүх албан хаагч цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, зайлшгүй шаардлагатай үед гадуур ажиллах тохиолдолд [redacted] тухай бүр хүсэлтээ оруулан илгээж хэвшсэн. Тайлант хугацаанд алба хаагчид тасалсан өдөр байхгүй.<br>Нэгжийн чиг үүргийн онцлогоос хамаарч алба хаагчид илүү цагаар ажиллах, гар утасны бэлэн байдлыг 24/7 цагаар ханган ажиллаж байна. Шөнийн цагаар давхар хяналтаар ажиллах үед илүү цагийг хэрхэн бүртгэх асуудлыг ЗУГ-тай зөвшилцсөний дагуу нэгжийн ГУАБ цаасаар бүртгэл хөтөлж байна.<br>Тайлант хугацаанд хэлтсийн алба хаагч нар 471 илүү цаг ажилласан байна. | 2024.01.01-2024.11.30 | 100% |
| 10. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 95% | 100% | - Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 692 албан бичиг, 31 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч шийдвэрлэсэн.<br>- Ирсэн бичгийг агуулгаар нь авч үзвэл хамтран ажиллах, сургалт, зөвлөгөөн зохион байгуулах, | 2024.01.01-2024.11.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нотлох баримт, мэдээлэл лавлагаа гаргуулах, судалгаа, тайлан, мэдээ ирүүлэх, албан бичгийн хариу, аж ахуйн нэгжийн тодорхойлолт, лавлагаа зэрэг байна. [redacted], бусад [redacted]<br>- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хууль"-ийг шинэчлэн боловсруулж батлуулах ажлын хэсэгт орж ажиллан гаалийн байгууллагын хариуцан хэрэгжүүлэх чиглэлд санал хүргүүлсэн.<br>- Ирсэн нийт албан бичгээс хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн нотлох баримт, мэдээлэл гаргуулах тухай албан бичиг 65.76 хувь, аж ахуй нэгжийн зөрчлийн тодорхойлолт, лавлагаа 3.54 хувь, харьяа гаалийн газар хороодод хүргүүлсэн чиглэл, үүрэг даалгаврын хариу 17.32 хувийг эзэлж байгаа бол тайлан төлөвлөгөө батлах ирүүлэх тухай, хуралдаан зарлах тухай, өргөдөл гомдол гаргах тухай болон бусад агуулгатай албан бичиг 13.38 хувийг эзэлж байна.<br><br>2. Газрын удирдлагаас бусад чиг үүргийн дагуу:<br>- Зөрчилтэй тэмцэх, аюулгүй байдлын газраас "Улсын хилээр бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт, шалгалт хийх, хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр гаалийн байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх, чадавхыг бэхжүүлэх зорилгоор видео сургалтын модуль бэлтгэх, VR сургалтын танхим байгуулах цогц төслийг бүрэн хэрэгжүүлж ГЕГ-ын Сургалтын төвд хүлээлгэн өгсөн.<br>- Гаалийн улсын байцагч [redacted] нь 2024 оны [redacted] дугаар сарын [redacted] өдрөөс 2024 оны [redacted] сарын [redacted] өдрүүдэд Замын-Үүд дэх гаалийн газарт томилолтоор Гаалийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2023 онд Дорноговь аймгийн Замын-үүд хилийн боомтоор [redacted] тээврийн хэрэгсэл гаалийн хилээр орох бүртгэл хийлгэж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүчингүй болгосон гэх асуудлаар Замын-Үүд дэх гаалийн газрын 6 гаалийн улсын ахлах байцаагч, Мөн ГУБ [redacted] нар 2023 онд Замын-Үүд боомтоор тээврийн хэрэгслийн хилээр [redacted] тээврийн хэрэгслийг шалгаж тус тээврийн хэрэгслийн хилээр нэвтрэх үеийн хяналтыг хэрэгжүүлж байсан [redacted] тайлбар мэдээлэл гаргуулан авсан. Шалгалтын үр дүнг Гаалийн ерөнхий газрын Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийн даргад танилцуулсан ажилсан.<br>Дээрх шалгалтаар илэрсэн зөрчилд Замын-Үүд дэх гаалийн газрын 1 ахлах байцаагчийг Гаалийн ерөнхий газрын сахилгын хороогоор оруулж сахилгын шийтгэл оногдуулсан.<br>- Гаалийн байгууллага хүний нөөцийг хангах ажлын хүрээнд тусгай шалгалтад тэнцэж, болзол шалгуурыг хanган ГЕГ болон харьяа газар, хороодод томилогдох 35 иргэнээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх сорилыг ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын алба хаагчидтай хамтран зохион байгуулж авсан.<br>- ЧХОУНБ-д газардсан Инчёон-Улаанбаатар чиглэлийн ОМ302 аяллын дугаартай онгоцоор ирсэн зорчигч нь [redacted] эдлэл, [redacted] шүр зэргийг биедээ нууж гаалийн байгууллагад мэдүүлэлгүйгээр улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн ба тухайн иргэний ачаа тээшийг ЧХОУНБГТ-ын [redacted] шалгах шалгалтын ажиллагааг явуулж хэлтэст 2024 оны [redacted] өдрийн [redacted] дотоод зурвасаар Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэст шилжүүлсэн.<br>- Удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу ажлын хэсэгт орж Замын-Үүд дэх гаалийн газрын гаалийн улсын ахлах байцаагч [redacted] нь гаалийн хяналт, шалгалт хийсэн гаалийн улсын байцаагчийн үйл ажиллагаанд гаалийн улсын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах үүргээ зохих ёсоор биелүүлээгүй байж болзошгүй гэх үндэслэлээр тус гаалийн газрын хил хамгаалах байгууллагаас ирүүлсэн гэх жагсаалтаас [redacted] тээврийн хэрэгслийн хэрэгслийн орох бүртгэлийг шалгаж, сахилгын хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.<br>- Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвийн гаалийн улсын байцаагч [redacted] мэдүүлгийн дугаартай бүрдүүлэлтэд холбогдох гар утсыг үндэслэлгүй үнэлсэн гэх асуудлыг шалгаж, байцаагчийн үйлдлийг Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэст шалгуулахаар 2024 [redacted] дугаар сарын [redacted] й дотоор зурвасаар шилжүүлсэн.<br>- Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвийн гаалийн улсын байцаагч [redacted] мэдүүлгийн дугаартай бүрдүүлэлтэд холбогдох гар утсыг үндэслэлгүй үнэлсэн гэх асуудлыг шалгаж, байцаагчийн үйлдлийг Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэст шалгуулахаар 2024 оны [redacted] дотоор зурвасаар шилжүүлсэн.<br>- Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсээс ирүүлсэн мэдээллийн дагуу [redacted] ийн чингэлгээр тээвэрлэсэн [redacted] чингэлэг дугаартай маалингын үрийг улсын хилээр "Амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх мэдэгдэл" авалгүй нэвтрүүлсэн гэх асуудлыг шалгаж, хяналт хэрэгжүүлсэн Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсээс "Амьтан, ургамал, бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдэгдэл" олгож буй асуудлыг шалгуулахаар Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэст шалгуулахаар 2024 оны [redacted] өдрийн [redacted] дотоор зурвасаар шилжүүлсэн. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусcан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | Удирдлагын академийн дунд хугацааны сургалтад хамрагдаж байгаа 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр төгсөнө. | 2024.01.01-2024.11.30 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
*( Албан тушаал )*

................ / Г.Ганзориг /
*( Нэр, гарын үсэг )*

2024.12.10.
*( Огноо )*

# ХАР ТАМХИ, МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ГАНЗОРИГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 61.39 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан дунд хугацааны сургалтад хамрагдах | | 13 |
| 2 | Удирдлагын манлайлал, удирдах арга барилаа сайжруулах чиглэлээр сургалтад хамрагдах | | 13 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 13 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | 14 |
| 2 | Удирдан зохион байгуулах | 13 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 13 |
| 4 | Манлайлах | 12 |
| 5 | Багаар ажиллах | 15 |
| 6 | Харилцаа | 14 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар | — |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 13.5 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 61.39 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний | 13 |

| | | |
|---|---|---|
| | биелэлт | 13.5 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | — |
| **Нийт оноо=**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 87.9 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч**

Гаалийн ерөнхий газрын дарга ............................ (Р.Отгонжаргал)

2024.12.19 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............................ (Г.Ганзориг)

2024.12.20 (огноо)